



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/310

Эрдэнэт

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017 оны 06 дугаар сарын 08-18-ны өдрүүдэд Орхон аймгийн уран бүтээлч Б.Сайханбаяр Улаанбаатар хотод “BLUE MOON” арт галерейд үзэсгэлэнгээ гаргах тул зардалд 1000000/ Нэг сая / төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Шаардагдах зардал 1000000 /Нэг сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтын “Боловсрол, эрүүл мэнд, спорт, урлагийн салбарын ажиллагсдын мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх” арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ